



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 66.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүрэгт 2025 оны он дамжин хэрэгжих болон 2026 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга, хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Дүүргийн Засаг даргын Орлогч

Гишүүд

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны дарга

Нарийн бичгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, үр дүнг тухай бүр танилцуулахыг ажлын хэсэг (Н.Бямбагэрэл)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Тамир)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

D:\Bichig hereg\2026 on\Zahiramj\Zahiramj.docx

1526012513